АКПАР-АУДИТ ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“НАВИТАС ФАНД ББСБ” ХХК
2024 оны 12 сарын 31-ний өдрөөр
тасалбар болгосон санхүүгийн тайлан

УЛААНБААТАР ХОТ
2025

“НАВИТАС ФАНД ББСБ” ХХК

Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр	“Навитас фанд ББСБ” ХХК (Цаашид “Компани” гэх) нь 2015 оны 12-р сарын 02-ны өдрийн үүсгэн байгуулагчийн 01 тоот шийдвэрээр Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.
Гэрчилгээ	Монгол улсын Улсын бүртгэлийн албанд 2015 оны 12-р сарын 03-ны өдөр бүртгүүлж 6025757 тоот регистр бүхий 9015005173 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээг дахин авсан.
Үндсэн үйл ажиллагаа	“Компани”-ийн үндсэн үйл ажиллагаа нь банк бус санхүүгийн зээл олгох үйл ажиллагаа болно.
Тусгай зөвшөөрөл	2024 оны 03-р сарын 04-ний өдөр Санхүүгийн зохицуулах хорооны 74-р тогтоолоор ТЗ 101/750 дугаартай “Банк бус санхүүгийн” үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан.

Хувьцаа Эзэмшигч	**Хувьцааны тоо**	**Эзэмшлийн хувь**
“Бридж” ХХК	25,000,100	100%
Гүйцэтгэх Удирдлага	Гүйцэтгэх захирал	Б.Батжаргал
Байнгын хаяг	**“Навитас фанд ББСБ” ХХК** Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, энхтайвны өргөн чөлөө, “Бридж плаза” оффис 3-302 тоот	
Аудитор	**“Акпар Аудит” ХХК** Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, МҮЭСТОрдон оффисын байр 307, 308 тоот	

НАВИТАС ФАНД ББСБ ХХК
Улаанбаатар-51, Энхтайваны өргөн чөлөө
Баянзүрх дүүрэг 14-р хороо, Бридж плаза
Утас: 11-450520 Факс: 11-458005
E-mail: batjargal.b@bridgecorporation.mn
УБД: 9011577070

2025.01.29 № 25/013

танай _____-ны № _____-д

АКПАР АУПИТ ХХК-Д

2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл

Энэхүү тайлангийн 3-5 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Навитас фанд ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх) 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилүүдийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС") -ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС"), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилүүдийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

"НАВИТАС ФАНД ББСБ" ХХК
NAVITAS FUND
NBFI LLC
9024031579
6025757 - СБА12208
УЛААНБААТАР ХОТ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БАТЖАРГАЛ

ЕРӨНХИЙ САНХҮҮЧ Б.ЛХАГВАЖАРГАЛ

Акпар Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар,
Баянгол дүүрэг, 2-р хороо,
МҮЭСТО -ны байр 307, 308 тоот

Утас : +976 70131599
Утас : +976 89051599

Хараат Бус Аудиторын Тайлан

“Навитас фанд ББСБ” ХХК-ийн
Хувьцаа эзэмшигчид:

Дүгнэлт

Бид Аудитын тухай хуулийн 9.1.1-д заасны дагуу “Навитас фанд ББСБ” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй, тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангууд нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу материаллаг алдаа, зөрчилгүй илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл - Нягтлан бодох бүртгэлийн суурь

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. АОУС-д заасан аудиторын хүлээх үүрэг, хариуцлагыг “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага” гэсэн хэсэгт тусгаж харуулав. Бид аудитын ажилд хамааралтай хараат бус байдлын болон ёс зүйн шаардлагуудыг бүрэн биелүүлж ажилласан. Бидний олж авсан баримт нотолгоонууд дээрх дүгнэлтийг гаргахад хангалттай, тохиромжтой гэж үзэж байна.

Санхүүгийн тайланг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох журмын дагуу бэлтгэсэн. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, журам нь зарим ялгаатай зүйлсээс бусдаар Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д суурилсан.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу бэлтгэж, үнэн зөв тайлагнаж, толилуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хуульд нийцүүлэн боловсруулан, мөрдөж ажиллах нь байгууллагын удирдлагын үүрэг юм.

Мөн түүнчлэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөрөнгийг аливаа залиланд өртүүлэхгүй байхаар дотоод хяналтын системийг бий болгох, байгууллагын үйл ажиллагааны болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурь, зарчмыг хангаж ажиллах нь байгууллагын удирдлагын хариуцлага юм.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Аудиторын гол зорилго нь үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас материаллаг буруу илэрхийллээс ангид эсэхэд дүгнэлт өгөхөд оршино. Тодорхой дүгнэлтэд хүрэхийн тулд АОУС-д нийцүүлэн боловсруулсан горимын дагуу шалгалт хийж, хангалттай, тохиромжтой баримт нотолгоо цуглуулах нь аудиторын үүрэг юм.

Аудитын горимуудыг батлагдсан төлөвлөгөөний дагуу аудитор өөрийн шийдлээр сонгох ба ирүүлсэн алдаа, зөрчил нь материаллаг буюу байгууллагын удирдлага болон хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх эсэхэд дүн шинжилгээ хийж, түүнд тохирсон дүгнэлт өгнө.

Аудитын шалгалтаар байнга алдаа зөрчил илрэх ёстой гэсэн ойлголт байж болохгүй бөгөөд бидний илрүүлсэн алдаа, зөрчил материаллаг бус бол түүнийг арилгуулах талаар тодорхой зөвлөгөө өгч ажиллана.

Цаасан болон цахим хэлбэрээр бэлтгэсэн аудитын ажлын баримтууд нь тус компанийн өмч бөгөөд аудиторын тайлан, зөвлөмжийн хамт 10 жил хадгална.

Б.ЭРДЭНЭСҮРЭН
ПАРТНЕР

2025-02-03

“НАВИТАС ФАНД ББСБ” ХХК
2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	Тодруулга	2024 он Мян.Төгрөг	2023 он Мян.Төгрөг
Хүүгийн орлого	**6**	216,344.7	-
Хүүгийн зардал		-	
Цэвэр хүүгийн орлого		**216,344.7**	-
Эрсдэлийн сангийн зардал		-	-
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого		**216,344.7**	-
Хүүгийн бус орлого, зардал	**7**	(84,998.1)	-
Бусад орлого, зардал	**8**	(3,745.1)	-
Татвар төлөхийн өмнөх ашиг		**127,601.5**	-
Орлогын татварын зардал	**9**	(5,629.5)	-
Цэвэр ашиг		**121,972.0**	-

8-15 дугаар хуудсан дахь тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“НАВИТАС ФАНД ББСБ” ХХК
2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	Тодруулга	2023.12.31 Мян.Төгрөг	2022.12.31 Мян.Төгрөг
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	**10**	1,073,291.4	-
Зээл	**11**	1,539,212.4	-
Бусад санхүүгийн хөрөнгө		-	-
Санхүүгийн хөрөнгийн дүн		-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн		**2,612,503.8**	**-**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	**12**	12,179.2	-
Биет бус хөрөнгө	**13**	4,680.6	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**16,859.8**	**-**
НИЙТ ХӨРӨНГӨ		**2,629,363.6**	**-**
Өмч ба Өр төлбөр			
Өр төлбөр			
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл			
Бусад өглөг	**14**	7,381.6	-
Өр төлбөрийн дүн		**7,381.6**	**-**
Өмч			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	**15**	2,500,010.0	-
Нэмж төлөгдсөн капитал		-	
Хуримтлагдсан ашиг		121,972.0	-
Өмчийн дүн		**2,621,982.0**	**-**
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		**2,629,363.6**	**-**

8-15 дугаар хуудсан дахь тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“НАВИТАС ФАНД ББСБ” ХХК

2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт өмч
	Мян.Төгрөг	Мян.Төгрөг	Мян.Төгрөг	Мян.Төгрөг	Мян.Төгрөг
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**-**	**-**	**-**	**-**	**-**
Тайлант жилийн цэвэр ашиг	2,500,010.0	-	-	-	**2,500,010.0**
	-	-	-	121,972.0	**121,972.0**
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**2,500,010.0**	**-**	**-**	**121,972.0**	**2,621,982.0**

8-15 дугаар хуудсан дахь тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“НАВИТАС ФАНД ББСБ” ХХК
2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлтүүд	2024 он Мян.Төгрөг	2023 он Мян.Төгрөг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн:	**451,097.4**	**-**
Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	370,477.8	
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	34,280.7	
Бусад мөнгөн орлого	46,338.9	
Мөнгөн зарлагын дүн:	**(1,877,826.0)**	**-**
Ажиллагчдад төлсөн	(1,780,144.0)	
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(31,729.9)	
Бараа материал худалдан авахад төлсөн	(10,472.7)	
Ашиглалтын зардалд төлсөн	(55,479.4)	
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн:	**(1,426,728.6)**	**-**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн:	**-**	**-**
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Мөнгөн зарлагын дүн:	**-**	**-**
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн:	**-**	**-**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн:	**-**	**-**
Зээл хүлээн авсан	-	-
Төрөл бүрийн хандив	-	-
Мөнгөн зарлагын дүн:	**-**	**-**
Зээл төлсөн мөнгө	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	**-**	**-**
Мөнгөн хөрөнгөд хамаарах валютын ханшийн зөрүү	-	-
Цэвэр мөнгөн дүн	**(1,426,728.6)**	**-**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**2,500,020.0**	**-**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**1,073,291.4**	**-**

8-15 дугаар хуудсан дахь тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“НАВИТАС ФАНД ББСБ” ХХК
2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

1. Компанийн талаарх мэдээлэл

1	Компанийн нэр	“Навитас фанд ББСБ” ХХК
2	Компанийн регистрийн дугаар	6025757
3	Компанийн байгуулагдсан он	2015
4	Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэр	“Бридж” ХХК
5	Компанийн эцсийн өмчлөгчийн нэр	Даваажав Ганхуяг
6	Компанийн үйл ажиллагааны чиглэл	Зээлийн үйл ажиллагаа
7	Компанийн хаяг байршил	Улаанбаатар, Баянзүрх, 14-р хороо, энхтайваны өргөн чөлөө, "Бридж плаза" Оффис 3-302 тоот

2. Тайлан бэлтгэсэн үндэслэл

“**НАВИТАС ФАНД ББСБ**” ХХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (НББОУСХ)-ноос гаргаж, мөрдүүлсэн Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) болон НББОУСХ-ны Тайлбарын Байнгын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн байна.

Түүхэн өртгийн зарчим дээр суурилан, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, журмын дагуу бэлтгэгдэн толилуулагдсан.

Компанийн үйл ажиллагааны болон тайлагнагч валют нь Монгол улсын мөнгөн тэмдэгт болох төгрөг бөгөөд санхүүгийн тайлан дахь дүнгүүд нь мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

Тасралтгүй байх зарчмын дагуу компани өөрийн бизнесийн үйл ажиллагааг ирээдүйд тасралтгүй үргэлжлэнэ гэж төсөөлж санхүүгийн тайлангаа бэлтгэсэн.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг доор толилуулав.

3. Эрсдэлийн удирдлагын зорилт болон бодлогууд

ББСБ-ын санхүүгийн удирдлагын бодлого нь учирч болзошгүй сөрөг нөлөөг багасгахын тулд хүүний хувь, зээл ба төлбөрийн чадварын эрсдэлүүд удирдахын зэрэгцээ зохицуулагч байгууллагаас тогтоосон эрсдэлийн хязгаарыг барих, эрсдэлийн нөлөөлөлд дүн шинжилгээ хийж, хяналт тавихыг зорьдог.

a) Хүүний түвшний эрсдэл

Хүүний түвшний эрсдэл нь санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал нь зах зээл дээрх хүүний түвшний хэлбэлзэлтэй холбоотойгоор үүсдэг. Хүүний түвшний эрсдэлийг зах зээл дээрх хамгийн боломжит хүүний түвшнийг баримтлах замаар удирддаг.

b) Төлбөрийн чадварын эрсдэл

ББСБ нь зээлийн бүх эргэн төлөлт хэвийн гэдгийг баталгаажуулахын тулд өөрийн зээл олгосон зээлчдэгчдийн зарцуулалт болон барьцаа хөрөнгийг идэвхитэй хянаж байдаг. ББСБ нь өөрийн төлбөрийн чадварын зохистой байдлын ерөнхий удирдлагын нэг хэсэг болгон, зээлчдэгчдийн хэрэгцээг хангахад хүрэлцэхүйц хэмжээний бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг бэлэн байлгадаг.

4. Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал нэг бүрийн бодит үнэ цэнийг ойролцоолон тооцоход (эдгээр үнэ цэнийг тооцох нь практик дээр боломжтой бол) дараах арга төсөөллүүдийг ашигладаг.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь богино хугацаат санхүүгийн хэрэглүүр учраас тэдгээрийн бүртгэлийн дүн нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байдаг.

Холбоотой талуудад өгөх өглөг: Холбоотой талуудад өгөх өглөгүүд нь хугацаагүй буюу хүссэн үед нь төлөх нөхцөлтэй учраас тэдгээрийн бүртгэлийн дүн нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байдаг.

5. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

a) Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд банкинд байршуулсан мөнгө болон касс дах бэлэн мөнгө, банк болон бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хугацаагүй хадгаламж, мөн худалдан авснаас хойшхи дуусах хугацаа нь 3 сар болон түүнээс бага байх, хөрвөх чадвар өндөртэй богино хугацаат хөрөнгө оруулалтууд орно.

b) Зээл

Иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийг энэ дансанд тусгана. Зээл нь эргэн төлөгдөхөд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах нөөцийг хассан цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн. Зээлийн хүүний хувь хэмжээг Монгол банкны хүүгийн бодлого, ББСБ-ын активаас олох орлого болон пассивт төлөх төлбөрийн дундаж хувь хэмжээ, үйл ажиллагааны зардал зэрэгтэй уялдуулан 0.5-4.5 хувиар тогтоохоор зээлийн үйл ажиллагааг зохицуулах журамд заасан байна.

c) Бараа материал

Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, тээвэрлэлтийн үе шатанд гарсан зардал ордог. ББСБ-ын бараа материалд үйл ажиллагаа явуулахад ашиглагдах бичиг хэрэг, хангамжийн материал орно.

d) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дараах зүйлсийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэнэ.

- Тавилга эд хогшил,
- Компьютер, дагалдах хэрэгсэл,
- Бусад хөрөнгө

Хөрөнгийн өртөгт худалдан авах болон барьж байгуулахтай шууд холбогдон гарсан зардлуудыг хамаарна.

Хэрэв Компани нь ирээдүйд тухайн хөрөнгөөс эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой үед хөрөнгийг орлуулсан өртгөөр хүлээн зөвшөөрнө. Бусад бүх зардлуудыг гарах үед нь ашиг, алдагдал руу бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийг борлуулсан болон данснаас хасахад үүссэн олз, гарзыг борлуулалтын үнэ болон хөрөнгийн дансны цэвэр үнийн зөрүүгээр тодорхойлох бөгөөд данснаас хассан өдөр ашиг, алдагдал руу бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийн өртгийг бууруулах зорилгоор үлдэх өртгийг тооцсоны дараа ашиглагдах хугацаанд үндэслэж шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

Үндсэн хөрөнгийг ашиглахаар тогтоосон хугацаа дараах байдалтай байна:

Үндсэн хөрөнгийн ангилал	Ашиглагдах хугацаа (жилээр)
Тавилга эд хогшил	10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	2 жил
Бусад хөрөнгө	10 жил

е) Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэх ба анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа түүний өртгөөс нь хуримтлагдсан хорогдуулга (тодорхой ашиглах хугацаатай хөрөнгийн хувьд) ба үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэнэ.

Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулгыг хүлээгдэж буй ашиглалтын хугацаанд шулуун шугамын аргаар ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

f) Дансны болон бусад өглөг

Дансны болон бусад өглөгүүдийг анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрч, анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

g) Татварын зардал

Татварын зардал нь тайлант үеийн болон хойшлогдсон татварын зардлын нийлбэрээс бүрддэг бөгөөд орлогын тайланд тусгадаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа балансын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татварын хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өр төлбөр юм.

h) Орлогыг хүлээн зөвшөөрөх

Хүүгийн орлого

Хүүгийн орлого ба зардлыг хуримтлуулан бүртгэж хөрөнгийн үр ашигт өгөөжийг харгалзан орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Үндсэн зээл эсвэл хүү эргэн төлөгдөлт нь эргэлзээтэй болсон үед хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрөхийг хойшлуулдаг. Монгол банкны шаардлагын дагуу хүүгийн төлбөр нь 90 хоногоор хугацаа хэтэрсэн тохиолдолд хүүг хүлээн зөвшөөрөхийг зогсоодог. Хүүг хүлээн зөвшөөрөхийг зогсоосон үед холбогдох хүүгийн авлагыг данснаас хасч балансын гадуур бүртгэдэг. Эргэн төлөгдөх эргэлзээтэй байдал арилсан нөхцөлд хүүгийн орлогыг аккурэл сууриар хүлээн зөвшөөрдөг.

Төлбөр хураамжийн орлого

Хэрэглэгчдэд үзүүлсэн санхүүгийн үйлчилгээндээ тэднээс төлбөр хураамж авдаг. Төлбөр хураамжийн орлогыг холбогдох үйлчилгээг үзүүлэх үед хүлээн зөвшөөрдөг.

i) Зардал хүлээн зөвшөөрөх

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид хуваарилснаас бусад мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

Зардлыг тухайн гарсан жил буюу цаг хугацаанд нь орлогын дэлгэрэнгүй тайланд хүлээн зөвшөөрнө.

j) Хувь нийлүүлсэн хөрөнгө

Хувь нийлүүлсэн хөрөнгө нь компанийн гаргасан хувьцааг илэрхийлэх бөгөөд хүлээн авсан дүнгээс хувьцаа гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжигддэг. Санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд компанийн гаргасан санхүүгийн хэрэгслүүдийг өмчөөр ангилж бүртгэнэ.

k) Тасралтгүй үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Ирээдүйд үйл ажиллагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх, эргэлзээ төрүүлэх нөхцөл байдал ажиглагдаагүй.

l) Тайлагналын дараах үйл явдал

Санхүүгийн тайлан бэлтгэсэн өдөр болон аудитын тайлангийн өдрийн хооронд тохиолдсон болон үйл ажиллагаанд нөлөөлөх томоохон өөрчлөлт, үйл явдал гараагүй болно.

6. Хүүгийн орлого

Үзүүлэлт	2024 он Мян.Төгрөг	2023 он Мян.Төгрөг
Иргэдэд олгосон зээлийн хүүгийн орлого/шимтгэл	1,759.2	-
Харилцах дансны хүүгийн орлого	36,605.6	-
Хадгаламжийн дансны хүүгийн орлого	14,745.2	-
Дотоодын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	34,280.7	-
Хэвийн зээлийн хүү	128,931.1	-
Торгуулийн хүүгийн орлого	22.9	-
	216,344.7	**-**

7. Хүүгийн бус орлого, зардал

Үзүүлэлт	2024 он Мян.Төгрөг	2023 он Мян.Төгрөг
Ханшийн тэгшитгэлийн орлого	25.0	-
Цалингийн зардал	(40,687.6)	-
НДШ-ын зардал	(4,953.7)	-
Сургалтын зардал	(1,750.0)	-
Мэргэжлийн үйлчилгээний зардал	(9,206.1)	-
Маркетингийн зардал	(10,450.3)	-
Элэгдлийн зардал	(2,782.4)	-
Түрээсийн зардал	(8,800.0)	-
Программ хангамж автомажуулалтын зардал	(4,340.0)	-
Бичиг хэргийн зардал	(237.0)	-
Харилцаа холбооны зардал	(622.6)	-
Шимтгэл хураамжийн зардал	(434.8)	-
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(20.3)	-
Бусад зардал	(738.3)	-
	(84,998.1)	**-**

8. Бусад орлого, зардал

Үзүүлэлт	2024 он Мян.Төгрөг	2023 он Мян.Төгрөг
Бусад олз	10.0	-
Зочин төлөөлөгч, баяр ёслолын зардал	(3,338.4)	-
Бусад зардал	(416.7)	-
	(3,745.1)	**-**

9. Орлогын татварын зардал

Үзүүлэлт	2024 он Мян.Төгрөг	2023 он Мян.Төгрөг
Орлогын татварын зардал	(5,629.5)	-
	(5,629.5)	**-**

10. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Үзүүлэлт	2024.12.31 Мян.Төгрөг	2023.12.31 Мян.Төгрөг
Касс дахь бэлэн мөнгө	1,733.4	-
Банкин дахь мөнгө	1,071,558.0	-
	1,073,291.4	**-**

Банкин дахь 1,073,291.4 мянган төгрөгийн үлдэгдэл нь банкны хяналтын хуулгаар баталгаажсан.

11. Зээл

2024 оны жилийн эцсийн байдлаар 1,525,800.1 төгрөгийн зээл нь хэвийн зээлд ангилагдсан байна. Энэ нь зээлийн багцын 100 хувийг эзэлж байна.

Зээлийн багцын чанар 2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар:

Зээлийн ангилал	2024.12.31 Мян.Төгрөг		2023.12.31 Мян.Төгрөг	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
Хэвийн зээл	1,525,800.1	100.00%	-	-
Анхаарал хандуулах зээл	-	-	-	-
Чанаргүй зээл, Үүнээс:	-	-	-	-
Хэвийн бус зээл	-	-	-	-
Эргэлзээтэй зээл	-	-	-	-
Муу зээл	-	-	-	-
Нийт зээлийн багц	**1,525,800.1**	**100.00%**	**-**	**-**
Хүүгийн авлага	26,335.1			
Зээлийн хойшлогдсон төлбөр	(12,922.8)			
Зээл /цэврээр/	**1,539,212.4**		**-**	

12. Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	Тавилга, эд хогшил Мян.Төгрөг	Компьютер, хэрэгсэл Мян.Төгрөг	Бусад үндсэн хөрөнгө Мян.Төгрөг	Нийт Мян.Төгрөг
Өртөг				
2023 оны 12-р сарын 31	**-**	**-**	**-**	**-**
Худалдаж авсан	6,006.6	7,150.0	2,369.4	**15,526.0**
Худалдсан	-	(829.4)	(1,599.4)	**(2,428.8)**
Данснаас хассан	-	-	-	**-**
2024 оны 12-р сарын 31	**6,006.6**	**6,320.6**	**770.0**	**13,097.2**
Элэгдэл				
2023 оны 12-р сарын 31	**-**	**-**	**-**	**-**
Байгуулсан	(96.9)	(808.4)	(13.1)	**(918.4)**
Данснаас хассан	-	0.2	0.2	**0.4**
2024 оны 12-р сарын 31	**(96.9)**	**(808.2)**	**(12.9)**	**(918.0)**
Нийт дансны үнэ				
2023 оны 12-р сарын 31	**-**	**-**	**-**	**-**
2024 оны 12-р сарын 31	**5,909.7**	**5,512.4**	**757.1**	**12,179.2**

13. Биет бус хөрөнгө

Үзүүлэлтүүд	Программ хангамж Мян.Төгрөг	Бусад хөрөнгө Мян.Төгрөг	Нийт Мян.Төгрөг
Өртөг			
2023 оны 12-р сарын 31	**-**	**-**	**-**
Нэмэгдсэн	6,545.0	-	**6,545.0**
Хасагдсан	-	-	-
2024 оны 12-р сарын 31	**6,545.0**	**-**	**6,545.0**
Хуримтлагдсан хорогдол			
2023 оны 12-р сарын 31	**-**	**-**	**-**
Тайлант жилд байгуулсан	(1,864.4)	-	**(1,864.4)**
Хасагдсан	-	-	-
2024 оны 12-р сарын 31	**(1,864.4)**	**-**	**(1,864.4)**
Дансны цэвэр үнэ			
2023 оны 12-р сарын 31	**-**	**-**	**-**
2024 оны 12-р сарын 31	**4,680.6**	**-**	**4,680.6**

14. Бусад өглөг

Үзүүлэлт	2024.12.31 Мян.Төгрөг	2023.12.31 Мян.Төгрөг
ААНОАТ-ын өглөг	5,629.5	-
Бусад татварын өглөг	1,752.1	-
	7,381.6	**-**

15. Хувь нийлүүлсэн хөрөнгө

Үзүүлэлт	2024.12.31 Мян.Төгрөг	2023.12.31 Мян.Төгрөг
Энгийн хувьцаа	2,500,010.0	-
	2,500,010.0	**-**

16. Зэрэгцүүлсэн үзүүлэлт

Тайлант жилийн тайлагналтай нийцүүлэх үүднээс тодорхой зарим зэрэгцүүлсэн үзүүлэлтүүдийг дахин ангилсан болно.

17. Тайлагналын өдрийн дараах үйл явдал

Удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлэх өөр бусад үйл явдал тайлант хугацаа дуусгавар болсон өдрөөс хойш санхүүгийн тайланг хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөн өдрийг хүртэлх хугацаанд гараагүй гэж үзэж байна.